PBSA AUDIT LLC | АУДИТ БАТАЛГААЖУУЛАЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 8-р хороо,
"ТАФ Бюлдинг" оффис, 703 тоот
Утас: (+976)-72330760, 99010760
И-майл: tcc.audit.mn@gmail.com

"МТМЖТ" БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

"МТМЖТ" ББСБ ХХК (цаашид Банк бус санхүүгийн байгууллага гэх)-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

"МТМЖТ" ББСБ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид "СТОУС" гэх), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журмуудын дагуу үнэн, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

Зөрчилгүй дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (цаашид АУОС гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчийн Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчийн ёс зүйн дүрэм (цаашид "НБЁЗОУСЗ-ийн дүрэм" гэх)-ийн дагуу тус байгууллагаас хараат бус, бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.1***Аудитын гол асуудлууд***

Бидний мэргэжлийн үнэлэмжээр аудитын гол асуудлууд нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудал юмаа. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Татварын тооцооллын үнэн зөв байдал

Татварын өр төлбөрийн тооцоололт болон татварын хууль тогтоомжийн хэрэгжүүлэлт нь үнэлэмж шаарддаг учраас бид татварын тооцооллын үнэн, зөв байдлыг аудитын гол асуудал гэж үзсэн.

Зах зээлийн эдийн засагт шилжих шилжилттэй холбоотойгоор Монгол улсын Засгийн газар бизнес болон эдийн засгийн бүтцэд өөрчлөлт хийсээр байна. Үүний үр дүнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хууль журмууд ч мөн өөрчлөгдсөөр байна.

Эрх бүхийн өөр өөр байгууллагууд татварын хуулийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийж төлбөр торгууль тавих хуулиар тогтоосон эрхтэй байдаг. Татварын хууль тогтоомжийн ойлголт дээр үндэслэн бүх татварыг үнэн зөв тодорхойлсон гэж итгэж байгаа боловч дээр дурдсан хүчин зүйлүүдээс үндэслэн банк бус санхүүгийн байгууллагад татварын эрсдэл байсаар байна.

Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээллийн талаар үүрэг хүлээнэ.Бусад мэдээлэл нь жилийн тайланд багтсан хэдий ч санхүүгийн тайлан ба аудиторын тайланд багтаагүй мэдээллээс бүрдэнэ.

Энэхүү санхүүгийн тайланд өгөх бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид бусад мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт өгөхгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд, бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуглуулсан мэдээллээс материаллаг хэмжээний алдаатай эсэхийг авч үзэх ёстой.

Бусад мэдээллийг уншиж, бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд, бид бусад горимыг гүйцэтгэж, бусад мэдээлэл материаллаг хэмжээний алдаа байгаа гэж үзсэн ба түүнийг залруулаагүй бол, залруулаагүй материаллаг хэмжээний алдааг манай

тайлангийн мэдээлэл хэрэглэгчдэд хүргэхийн тулд бид зохистой арга хэмжээ авахыг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.
Хэрэв бид банк бус санхүүгийн байгууллагад аудит хийсэн санхүүгийн тайлан, байгууллагын орчны талаарх бидний ойлголтод материаллаг хэмжээний алдаа байна гэж үзвэл, бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээ авна.

Санхүүгийн Тайлантай холбоотой Удирдлага болон Засаглах Эрх Бүхий Этгээдийн Үүрэг
Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэн шударгаар илэрхийлэх,санхүүгийн тайланг алдаа эсвэл санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг хэмжээний алдаагүйгээр бэлтгэж, шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай гэж тогтоосон дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй
Санхүүгийн тайланг бэлтгэхдээ банк бус санхүүгийн байгууллага татан буулгах, үйл ажиллагааг нь зогсоох, эсвэл үүнээс өөр боломжит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага байгууллагын үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг ашиглан санхүүгийн тайланг бэлтгэх үүрэгтэй. Засаглах эрх бүхий этгээд нь банк бус санхүүгийн байгууллага санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Аудиторын үүрэг
Санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа, эсвэл санаатай зальт үйлдлийн улмаас материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэслэлтэй нотолгоо олж авах болон бидний дүгнэлтийг агуулсан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудит нь байнга материаллаг хэмжээний алдааг илрүүлдэг гэсэн баталгаа болохгүй. Алдаатай илэрхийлэл нь алдаа эсвэл санаатай зальт үүдлээс үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайлан
д үндэслэн шийдвэр гаргах санхүүгийн тайлангийн хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үздэг.

Тайлангийн хэрэглээ
Бид энэхүү тайланг хуулийн этгээд болох "МТМЖТ" ББСБ ХХК-ийн удирдах зөвлөлд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

ТӨГС СУУРЬ СТАНДАРТ АУДИТ ХХК

Т.Батсайхан захирал,
"Төгс Суурь Стандарт Аудит" ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2025/01/31

СТА-1

"МТМЖТ ББСБ" ХХК **РД: 5764408**

2024 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл (төгрөг)	Эцсийн үлдэгдэл (төгрөг)
1	**ХӨРӨНГӨ**		
1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	31,324,261.88	70,046,428.57
1.2	Зээл	683,322,588.95	1,261,070,414.86
1.4	Үүсмэл санхүүгийн хөрөнгө		
1.6	Бусад санхүүгийн хөрөнгө	12,686,316.08	63,612,197.42
1.7	**Санхүүгийн хөрөнгийн дүн**	**727,333,166.91**	**1,394,729,040.85**
1.8	Татвар, НДШ-ийн авлага		1,249,600.48
1.9	Үндсэн хөрөнгө		357,041.67
1.10	Биет бус хөрөнгө		
1.11	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.12	Бусад санхүүгийн бус хөрөнгө	3,040,840.56	
1.13	**Санхүүгийн бус хөрөнгийн дүн**	**3,040,840.56**	**1,606,642.15**
1.14	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**730,374,007.47**	**1,396,335,683.00**
2	**Өр төлбөр**		
2.1	Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр		
2.2	Банк, санхүүгийн байгууллагаас татсан э›	500,000,000.00	608,853,630.85
2.5	Бусад санхүүгийн өр төлбөр	2,530,936.24	2,467,819.48
2.6	Хоёрдогч өглөг		
2.7	Давуу эрхийн хувьцаа (өр төлбөр)		
2.8	**Санхүүгийн өр төлбөрийн дүн**	**502,530,936.24**	**611,321,450.33**
2.13	**Санхүүгийн бус өр төлбөрийн дүн**	**0.00**	**0.00**
2.14.	**НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН**	**502,530,936.24**	**611,321,450.33**
3	**Өмч**		
3.1	Хувь нийлүүлсэн хөрөнгө	200,436,000.00	665,436,000.00
3.2	Өмчийн бусад хэсэг		
3.3	Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	27,407,071.23	119,578,232.67
3.4	**НИЙТ ӨМЧИЙН ДҮН**	**227,843,071.23**	**785,014,232.67**
3.5	**НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН**	**730,374,007.47**	**1,396,335,683.00**

PBS-AUDIT

СТА-2

"МТМЖТ ББСБ" ХХК ***РД: 5764408***

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (төгрөг)	Эцсийн үлдэгдэл (төгрөг)
1	**Хүүгийн орлого**		
1.3	Зээлийн	130,106,920.60	262,071,735.89
1.6	(Хүүгийн орлогын буцаалт)		
1.7	**Хүүгийн орлогын дүн**	**130,106,920.60**	**262,071,735.89**
2.2	Зээлийн	57,333,260.27	108,925,890.41
2.6	**Хүүгийн зардлын дүн**	**57,333,260.27**	**108,925,890.41**
3	**3.Хүүгийн цэвэр орлого (1.7-2.6)**	**72,773,660.33**	**153,145,845.48**
4	Эрсдэлийн сангийн зардал	43,683,110.50	53,283,031.60
5	**Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого (3-4)**	**29,090,549.83**	**99,862,813.88**
6	**Бусад орлого**	**678,060.87**	**13,834,511.05**
6.1	Хүүгийн бус орлого	678,060.87	834,641.87
6.2	Бусад орлого, олз		12,999,869.18
7	**Бусад зардал**	**27,917,528.65**	**21,526,163.49**
7.1	Хүүгийн бус зардал	27,727,532.88	21,526,163.49
7.2	Бусад зардал, гарз	189,995.77	-
8	**Татварын өмнөх ашиг, алдагдал (5+6-7)**	**1,851,082.05**	**92,171,161.44**
9	Орлогын татварын зардал	**18,510.82**	
10	**Татварын дараах ашиг, алдагдал (8-9)**	**1,832,571.23**	**92,171,161.44**
11	Зогсоосон үйл ажиллагааны цэвэр орлого, зардал		
12	**Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал (10+11)**	**1,832,571.23**	**92,171,161.44**
13	.Бусад дэлгэрэнгүй орлого	-	12,999,869.18
14	**Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (12+13)**	**1,832,571.23**	**105,171,030.62**

PBS-AUDIT

СТА-3

"МТМЖТ ББСБ" ХХК

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

№	Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.0	0.0	
2	Залруулсан үлдэгдэл	0.0	0.0	**0.0**
3	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	27,407,071.2	**27,407,071.2**
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	**0.0**
5	Өмчид гарсан өөрчлөлт	200,436,000.0	0.0	**200,436,000.0**
6	Хуваарилсан ногдол ашиг	0.0	0.0	**0.0**
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	**0.0**
8	**2023 ОНЫ 12 -Р САРЫН 31-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ**	**200,436,000.0**	**27,407,071.2**	**227,843,071.2**
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			**0.0**
10	Залруулсан үлдэгдэл	200,436,000.0	27,407,071.2	**227,843,071.2**
11	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	0.0	92,171,161.4	**92,171,161.4**
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.0	0.0	**0.0**
13	Өмчид гарсан өөрчлөлт	465,000,000.0	0.0	**465,000,000.0**
14	Хуваарилсан ногдол ашиг	0.0	0.0	**0.0**
15	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.0	0.0	**0.0**
16	**2024 ОНЫ 12-Р САРЫН 31-НЫ ӨДРИЙН ҮЛДЭГДЭЛ**	**665,436,000.0**	**119,578,232.7**	**785,014,232.7**

3 PBS-AUDIT

СТА-4

"МТМЖТ ББСБ" ХХК

2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл (төгрөг)	Эцсийн үлдэгдэл (төгрөг)
1	**ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**		
1.1	Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	813,854,583.58	1,178,485,543.78
1.5	Бусад	678,060.87	
1.6	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**814,532,644.45**	**1,178,485,543.78**
1.7	Олгосон зээл	706,442,153.43	1,584,550,750.00
1.11	Ажиллагсдад олгосон	17,801,204.82	11,809,090.90
1.12	Татвар, нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,225,150.60	3,617,181.80
1.14	Бусад	1,741,812.95	4,786,354.39
1.15	**Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**728,210,321.80**	**1,604,763,377.09**
1.16	**Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**86,322,322.65**	**(426,277,833.31)**
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2.12	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага		
2.13	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3.3	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		465,000,000.00
3.5	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого**	**-**	**465,000,000.00**
3.6	Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн	57,333,260.77	
3.10	**Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага**	**57,333,260.77**	**-**
3.11	**1 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн**	**(57,333,260.77)**	**465,000,000.00**
5	**Бүх цэвэр мөнгөн гүйлгээ**	**28,989,061.88**	**38,722,166.69**
6	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл**	**2,335,200.00**	**31,324,261.88**
7	**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл**	**31,324,261.88**	**70,046,428.57**

4 PBS-AUDIT